

## “ХҮНДЭТ ДОКТОР” ЦОЛ ӨРГӨМЖЛӨВ

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн хурлын 2008.03.27-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэнгийн захирал Р.Б.Рыбаковт Олон улс судлалын хүрээлэнгийн “Хүндэт доктор” цол олгов.

Р.Б.Рыбаков 1938 оны 3 сарын 28-нд Москвад төрсөн. 1963 онд Москвагийн улсын их сургуулийн дэргэдэх Дорно дахины хэлний дээд сургуулийг дорно дахин, энэтхэг судлаач мэргэжлээр төгссөн. 1966 оноос Дорно дахины хүрээлэнд ажиллаж байгаа бөгөөд 1994 оноос тус хүрээлэнгийн захирлаар ажиллаж байна. Түүнчлэн Дорно дахины их сургуулийн ерөнхийлөгчийн алба хашдаг.

Тэрээр колонийн болон тусгаар тогтнолын үеийн, түүнчлэн глобалчлалын үеийн Энэтхэгийн соёлын асуудал, Энэтхэгийн соёлын өвийн талаар голлон судалгаа хийдэг (200 гаруй бүтээлтэй). Р.Б.Рыбаков нь олон улсын хурал, конференцид оролцон олон тооны илтгэл тавьдагийн дотор Монгол Улсад болсон Олон улсын монгол судлаачдын хуралд оросын монгол судлаач эрдэмтдийг ахлан оролцож, сонирхолтой илтгэл олныг тавьж байсан. ОХУ-ын монгол судлалын нийгэмлэгийн ерөнхийлөгчийн үүрэгт ажлыг гүйцэтгэдэг бөгөөд Монгол улсын хүндэт медаль, одонгоор шагнуулж байв.